

Банкуудын ипотекийн зээлийн тайлан

2016 оны 12 дугаар сар


ХУРААНГУЙ:

- ❖ Тухайн сард 1224 зээлдэгч шинээр ипотекийн зээлд хамрагдсанаар нийт зээлдэгчдийн тоо 89156-д хүрчээ.
- ❖ Ипотекийн зээлийн нийт үлдэгдэл 4,018.3 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүний 3,115.9 тэрбум төгрөгийн зээл нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл байна.
- ❖ Шинээр олгосон зээл өмнөх сараас 16.7%-иар, төлөгдсөн зээл 1.8%-иар тус тус өссөн байна.
- ❖ Тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 10.3%-тай байлаа.
- ❖ Тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа 18.6 жил байна.
- ❖ Нэг зээлдэгчид ногдох тухайн сард олгосон зээлийн хэмжээ дунджаар 61.8 сая төгрөг хүрч өмнөх сараас 1.4 сая төгрөгөөр өссөн байна.
- ❖ Ипотекийн зээлийн үлдэгдэлд эзлэх хугацаа хэтэрсэн зээл 2.5%, чанаргүй зээл 1.4%-тай байна.

1. Ипотекийн зээлийн үлдэгдэл


Тайлант сарын эцэст ипотекийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт өмнөх сартай харьцуулахад 0.5 нэгж хувиар өссөн бол өмнөх оны мөн үеэс 3.6 нэгж хувиар буурч 17.1 хувь байна.

Зураг 1. Ипотекийн зээлийн үлдэгдэл, жилийн өсөлт



Тайлант сарын эцэст ипотекийн зээлийн үлдэгдлийн 77.5 хувь буюу 3115.9 тэрбум төгрөгийг “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл (жилийн 5 болон 8 хувийн хүүтэй зээл, эдгээр зээлд шилжүүлсэн зээл), 20.0 хувийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 2.4 хувийг бусад эх үүсвэрээр олгосон зээл бүрдүүлж байна.


Зураг 2. Ипотекийн зээлийн үлдэгдэл, эх үүсвэрээр



2016 оны 12 дугаар сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдлийн 99.3 хувь нь төгрөгийн, 0.7 хувь нь валютын зээл байна.

Тайлант сард ипотекийн зээлийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн зээл хувь 2.5 болж өмнөх сараас 0.6 нэгж хувиар буурсан бол чанаргүй зээл 1.4 хувьд хүрч 0.1 нэгж хувиар өссөн байна.


Зураг 3. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл



2. Тайлант сард олгосон зээл

Тухайн сард олгосон ипотекийн зээл өмнөх сараас 16.7 хувиар, өмнөх оны мөн үеэс 61.4 хувиар тус тус өссөн байна.

Зураг 4. Тухайн сард олгосон зээл



Тайлант сард нийт 75.6 тэрбум төгрөгийн зээл олгосон бөгөөд үүнээс 67.5 хувь буюу 51.0 тэрбум төгрөг нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл,

32.5 хувь буюу 24.5 тэрбум төгрөг нь банкуудын өөрийн эх үүсвэрээс олгосон зээл байна.


Нэг зээлдэгчид ногдох олгосон зээлийн хэмжээ 2016 оны 12 дугаар сарын байдлаар 61.8 сая төгрөг байна.

Зураг 5. Нэг хүнд ногдох тухайн сард олгосон зээл



Тухайн сард 37.2 тэрбум төгрөгийн ипотекийн зээл төлөгдсөн нь өмнөх оны мөн үеэс 38.5 хувиар, өмнөх сараас 1.8 хувиар өссөн үзүүлэлт юм.

Зураг 6. Тухайн сард шинээр олгосон, төлөгдсөн зээл



3. Зээлдэгчдийн тоо

Тайлант сард нийт 1224 зээлдэгч шинээр ипотекийн зээлд хамрагдсанаас 735 зээлдэгч “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд, 489 зээлдэгч банкны

өөрийн эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.

Зураг 7. Тухайн сард зээл авсан зээлдэгчдийн тоо, сарын өсөлт




2016 оны 12 дугаар сарын байдлаар нийт 89156 иргэн ипотекийн зээлтэй байгаагаас 65412 нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд (үүнээс 3945 нь 5 хувийн хүүтэй зээлд, 1329 нь 8 хувиас 5 хувь руу шилжсэн зээлд хамрагджээ), 20547 нь банкуудын өөрийн эх үүсвэрийн зээлд, 3197 нь бусад эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.

4. Зээлийн хугацаа

Тайлант сард банкууд 3 сараас 30 жилийн хугацаатай зээл олгосон бөгөөд жигнэсэн дундаж хугацаа нь 18.6 жил байна. Ипотекийн зээлийн үлдэгдлийн жигнэсэн дундаж хугацаа 2016 оны 12 дугаар сарын байдлаар 16.8 жил байна.

Тухайн сард олгосон зээлийн дийлэнх буюу 34.3 хувь нь 16-20 жилийн хугацаатайгаар олгогдсон байгаа бол нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 71.9 хувь нь 16-20 жил, 17.0 хувь нь 11-15 жил, 9.1 хувь нь 6-10 жил, 1.6 хувь нь 1-5 жилийн хугацаатай байна.

Зураг 8. Тухайн сард олгосон зээл, хугацааны ангилалаар



5. Зээлийн хүү

Банкуудын 2016 оны 12 дугаар сард олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 10.3 хувь байна.

Зураг 9. Тухайн сард олгосон зээлийн ЖД хүү



Банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 15.3 хувь байв.

Банкуудын ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 8.0-18.4 хувийн хооронд байлаа.

Хавсралт 1-д банкуудын ипотекийн зээлийн нэгдсэн тайланг харуулав.

Он	Сар	Ипотекийн зээлийн үлдэгдэл (сая төг.)	Үүнээс:		Тайлант сард шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа (жилээр)	Тухайн сард олгосон зээлийн жилийн ЖДХүү, (%)	Нийт зээлдэгч (тоогоор)	Үүнээс:	
			ОСИССТБ хөтөлбөрийн зээл					ОСИССТБ хөтөлбөрийн зээлтэй	
2008	12	217,977.5			8.4	19.8	16,522		
2009	12	226,040.6			8.6	18.7	16,784		
2010	12	333,776.6			9.6	16.0	16,700		
2011	12	669,662.8			12.9	14.8	26,869		
2012	12	845,204.4			13.0	15.3	29,887		
2013	12	1,938,945.3	1,248,633.8		16.1	9.9	48,320	30,600	
2014	1	2,021,424.9	1,324,898.9		16.2	9.8	49,731	32,190	
	2	2,121,802.6	1,382,084.1		16.1	9.9	53,611	33,346	
	3	2,193,368.6	1,451,938.1		15.9	9.9	54,787	34,632	
	4	2,280,503.5	1,538,506.8		16.0	9.8	56,137	36,081	
	5	2,365,349.5	1,618,127.2		15.8	10.0	57,579	37,488	
	6	2,440,007.1	1,684,583.9		15.2	10.5	58,793	38,659	
	7	2,492,105.2	1,728,222.8		15.7	10.7	59,756	39,507	
	8	2,553,827.2	1,780,078.3		15.6	10.5	60,851	40,405	
	9	2,619,161.1	1,833,494.0		15.5	10.6	62,017	41,390	
	10	2,703,792.6	1,903,636.6		15.8	10.4	63,652	42,772	
	11	2,762,726.8	1,954,341.3		16.2	10.3	64,577	43,621	
	12	2,844,706.3	2,027,952.9		16.7	9.9	66,334	45,283	
2015	1	2,898,731.0	2,072,894.5		16.3	10.2	67,233	46,134	
	2	2,949,116.5	2,121,339.7		16.6	9.7	68,126	47,108	
	3	3,015,535.1	2,196,795.5		16.5	9.2	69,269	48,512	
	4	3,082,551.7	2,263,794.5		16.6	9.6	70,498	49,691	
	5	3,128,182.4	2,305,308.1		16.4	10.3	71,355	50,462	
	6	3,192,029.1	2,363,999.7		16.4	9.6	72,412	51,438	
	7	3,230,507.8	2,400,625.2		16.1	9.9	73,208	52,181	
	8	3,267,175.5	2,433,968.6		16.3	10.0	73,949	52,858	
	9	3,319,711.8	2,481,556.8		16.2	9.6	74,848	53,643	
	10	3,370,510.2	2,534,505.4		16.8	9.4	75,877	54,612	
	11	3,412,929.6	2,570,150.9		16.4	10.0	76,583	55,295	
	12	3,432,957.6	2,590,987.6		16.7	8.8	77,105	55,830	
2016	1	3,434,849.9	2,595,234.1		16.3	10.1	77,226	56,031	
	2	3,459,596.6	2,623,837.0		16.6	9.2	77,673	56,577	
	3	3,565,687.2	2,679,829.3		17.1	8.8	81,015	57,659	
	4	3,625,870.6	2,751,292.4		16.7	8.2	82,156	59,001	
	5	3,697,056.7	2,832,261.7		19.7	8.3	83,280	60,455	
	6	3,792,276.2	2,929,375.2		19.1	7.7	84,906	62,080	
	7	3,849,221.0	2,995,847.0		19.5	7.7	85,622	63,146	
	8	3,886,362.9	3,029,623.4		19.0	8.4	86,221	63,729	
	9	3,943,037.2	3,047,579.5		19.7	8.7	87,925	64,081	
	10	3,950,186.6	3,052,251.0		18.1	9.1	88,044	64,277	
	11	3,979,535.9	3,082,876.9		18.8	9.2	88,555	64,868	
	12	4,018,298.5	3,115,908.9		18.6	10.3	89,156	65,412	

Хавсралт 2-г Орон нутгийн банкуудын ипотекийн зээлийн тайлан

2016 оны 12 дугаар сарын байдлаар

2016 оны 12 дугаар сарын байдлаар банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн 76.8 хувийг Улаанбаатар хотод, 23.2 хувийг хөдөө орон нутагт олгосон ипотекийн зээл бүрдүүлжээ. Хөдөө орон нутаг дахь ипотекийн зээлийн үлдэгдлийн 14.1 хувь буюу 130.7 тэрбум төгрөг Орхон аймагт, 13.9 хувь буюу 128.2 тэрбум төгрөг Дархан-Уул аймагт, 8.7 хувь буюу 80.0 тэрбум төгрөг Дорноговь аймагт ногдож байна.

Аймгууд	Ипотекийн зээлийн		Үүнээс ОСИСТБХ-ийн зээл		Тухайн сард олгосон ипотекийн зээлийн жилийн ЖДХугацаа	Тухайн сард олгосон ипотекийн зээлийн ЖДХүү (жилээр)	Нийт зээлдэгчдийн тоо	Үүнээс: ОСИСТБ хөтөлбөрийн зээлтэй
	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь				
1 Улаанбаатар	3,055,630.0	76.78	2,515,134.1	81.58	23.2	10.8	60569	45,496
2 Орхон	130,680.5	3.28	85,555.5	2.78	15.1	11.8	3297	2,834
3 Дархан-Уул	128,157.3	3.22	93,717.7	3.04	18.5	11.7	3703	3,178
4 Дорноговь	80,010.7	2.01	52,703.6	1.71	13.2	14.0	2319	1,841
5 Дорнод	59,599.5	1.50	41,889.5	1.36	17.5	8.8	1884	1,622
6 Увс	52,726.4	1.32	28,335.6	0.92	18.4	8.1	1676	906
7 Сэлэнгэ	49,834.4	1.25	34,423.8	1.12	20.2	11.2	1706	1,161
8 Өвөрхангай	46,808.4	1.18	27,803.9	0.90	12.7	11.5	1647	906
9 Ховд	46,741.4	1.17	26,285.2	0.85	16.5	9.5	1457	1,092
10 Өмнөговь	45,499.3	1.14	27,933.3	0.91	21.1	9.5	1263	893
11 Баянхонгор	33,849.0	0.85	18,587.6	0.60	14.6	8.4	1088	811
12 Сүхбаатар	32,218.0	0.81	17,975.0	0.58	11.3	19.1	1061	659
13 Архангай	29,757.9	0.75	16,151.7	0.52	14.9	13.1	862	564
14 Баян-Өлгий	26,287.0	0.66	11,289.8	0.37	20.0	9.7	1174	406
15 Хөвсгөл	23,943.4	0.60	8,971.1	0.29	10.7	12.0	921	314
16 Говь-Алтай	23,745.5	0.60	15,838.0	0.51	16.4	7.9	763	550
17 Хэнтий	22,789.7	0.57	12,367.2	0.40	15.9	10.1	673	498
18 Завхан	22,624.8	0.57	10,835.2	0.35	20.7	10.7	799	355
19 Төв	20,799.8	0.52	10,942.4	0.35	15.2	11.1	646	364
20 Дундговь	18,427.1	0.46	9,890.2	0.32	20.2	10.8	599	388
21 Булган	14,922.4	0.37	5,462.5	0.18	12.4	13.8	519	200
22 Говьсүмбэр	14,483.5	0.36	10,784.1	0.35	16.4	16.7	530	374
Нийт	4,018,298.5	1.00	3,115,908.9	1.00	19.7	10.3	89156	65412